

2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дорноговь аймаг, Сайншанд сумын нутагт байрлах “Төмөр
зам болон авто тээврийн ачилт буулгалтын талбай” төсөл

“ШИЖИР
ЗҮҮНБАЯН
ХӨГЖИЛ” ХХК

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АГУУЛГА

ОРШИЛ	4
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1. Төслийн нэр	5
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага	5
1.3. Төслийн байршил	5
1.4. Төслийн хүчин чадал, техник технологи	6
1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга	6
1.4.2. Төслийн дэд бүтцийн шийдлийн мэдээлэл	9
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	13
2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл	13
2.2. Газрын гадарга	13
2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг	14
2.4. Гадаргын болон газрын доорх ус	15
2.5. Хөрсөн бүрхэвч	16
2.6. Ургамлан нөмрөг	18
2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил	19
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	20
3.1. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд	20
3.2. Төслийн гол сөрөг нөлөөлөл	26
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	29
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	35
ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	38
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	41
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	43
АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	46
АРВАН ХОЁР. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	47
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	48

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил	5
Зураг 2. Ачилт хийж буй байдал.....	6
Зураг 3. Ачаа тээвэрлэлт.....	6
Зураг 4. Талбайн ерөнхий зохион байгуулалт	7
Зураг 5. Үйл ажиллагааны технологи дараалал.....	7
Зураг 6. Төслийн ачилт буулгалтын талбай.....	8
Зураг 7. Авто пүү, пүүний байр	8
Зураг 8. Төслийн техник, тоног төхөөрөмж.....	9
Зураг 9. Төслийн талбайн оффис	9
Зураг 10. Гэрэлтүүлэг.....	10
Зураг 11. Цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг.....	10
Зураг 12. Дулаан хангамжийн эх үүсвэр цахилгаан халаагуур.....	11
Зураг 13. Шинээр байгуулсан төмөр зам, бүдүүвч зураг.....	12
Зураг 14. Зүүнбаян-төслийн талбай орчмын сайжруулсан шороон зам.....	12
Зураг 15. Агаарын температурын жил, сарын явц	13
Зураг 16. Төслийн талбай орчмын геоморфологи.....	14
Зураг 17. Төслийн талбай орчмын геологийн тогтоц.....	15
Зураг 18. Төслийн талбай орчмын газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт	16
Зураг 19. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч.....	17
Зураг 20. Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг	18
Зураг 21. Ачилт, буулгалтын талбайгаас ялгарах TSP тоосны жилийн дундаж агууламж, мкг/м ³	20
Зураг 22. Ачилт, буулгалтын талбайгаас ялгарах PM10 тоосны жилийн дундаж агууламж, мкг/м ³	20
Зураг 23. Төслийн үйл ажиллагааны явцад илрэх эерэг ба сөрөг нөлөөллийн эзлэх хувь.....	27
Зураг 24. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөлийн	27
Зураг 25. Тэрбум модны хүрээнд тарих модны талбайн байршил	36
Зураг 26. Тэрбум модны хүрээнд тарих модны талбай	36
Зураг 27. Тарих модны байршлын төлөвлөгөө.....	37
Зураг 28. Гадаа байрлуулах хогийн савны жишээ.....	42
Зураг 29. Мониторингийн цэгүүдийн байршил.....	43

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд	5
Хүснэгт 2. Агаарт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин	21
Хүснэгт 3. Хөрсөнд үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин	22
Хүснэгт 4. Газрын гадаргад үзүүлэх болдошгүй нөлөөллийн түвшин	23
Хүснэгт 5. Усны нөөц, чанарт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин.....	23
Хүснэгт 6. Ургамлан нөмрөгт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин	24
Хүснэгт 7. Амьтны аймагт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин.....	24
Хүснэгт 8. Нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн түвшин	26
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	30
Хүснэгт 10. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	35
Хүснэгт 11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	38
Хүснэгт 12. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	39
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	41
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил	43
Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	44
Хүснэгт 16. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ.....	46
Хүснэгт 17. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	47
Хүснэгт 18. БОМТ-ний нийт зардал, мян.төг	48

ОРШИЛ

“Шижир зүүнбаян хөгжил” ХХК нь 2021 оны 06 дугаар сарын 11-нд үүсгэн байгуулагдсан. Манай компани нь Дорноговь аймгийн Сайншанд сумын 5-р багийн нутаг Зүүнбаянд байрлан үйл ажиллагаа явуулж байна.

Манай “Шижир зүүнбаян хөгжил” ХХК-ийн Зүүнбаян гаалийн хяналтын бүс нь 2022 оны 09 сарын 08-ний өдөр албан ёсоор гаалийн хяналтын бүсээр зарлагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн.

“Шижир зүүнбаян хөгжил” ХХК нь Дорноговь аймгийн Засаг даргын 2022 оны 01 сарын 28-ны өдрийн А/81 тоот шийдвэрээр олгосон газар эзэмшүүлэх зөвшөөрлийн дагуу тус нүүрс ачиж буулгах талбай нь төмөр зам болон автомашинаар ирсэн нүүрсийг хүлээн авч буулган, чингэлэгт ачиж төмөр замаар экспортод гаргах хүчин чадал бүхий 30 га гаалийн хяналтын бүс бөгөөд 2022 оны 09-р сарын 08-ны өдрийн А/159 тоот тушаалаар ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС-ээр зарлуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Тус талбай нь авто зам, автомашины зогсоол, 2112 м урт 2 салаа төмөр зам, Талбайн гэрэлтүүлэг 10 ширхэг, Авто, вагон пүү 2 ширхэг, Ган татлага 3 ширхэг, Чингэлэг сууц оффис, Хяналтын камер 24 ширхэг, Талбайд чиглэл заасан тэмдэг тэмдэглэгээнүүд, Чингэлэг ачиж буулгах талбай зэрэг гаалийн хяналтын талбайн бүх шаардлагыг хангасан гаалийн хяналтын бүс юм.

Монгол улсын экспортын бараа бүтээгдэхүүний хэмжээг өсгөх, улсын төсөвт төлөх татварын орлогыг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох зорилготой. УБТЗ-ын Зүүнбаянгийн өртөөнд шинээр нурмаг ачаа шилжүүлэн ачих зориулалт бүхий салбар төмөр зам ашиглалтанд орсноор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын хүрээнд хийгдэх ажлуудын зорилтууд хангагдах бөгөөд замчин, механизатор ачигч зэрэг зөвхөн төмөр замын чиглэлээр 30 орчим ажлын байр шинээр бий болох зэрэг улс орны эдийн засгийн өсөлтийг тодорхой хэмжээнд хангах ач холбогдолтой юм.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2022 онд “Нью гидро проект” ХХК боловсруулан Байгаль орчин аялал жуулчлалын яамаар баталгаажуулсан.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Төмөр зам болон авто тээврийн ачилт буулгалтын талбай” төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: “Шижир зүүнбаян хөгжил” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 0611008300


Регистрийн дугаар: 3323374

Хаяг: Дорноговь аймаг, Сайншанд сум, 5-р баг, Зүүнбаян, Манхан 3, 314.

Утас: 99087158

1.3. Төслийн байршил

Төсөл хэрэгжих талбай нь засаг захиргааны хуваарилалтаар Дорноговь аймгийн төв Сайншанд сумын 5-р багийн (Зүүнбаян) нутаг дэвсгэрт 30 га талбайд байрлана. Талбай нь Улаанбаатар хотоос 450 км, Сайншанд сумаас 50 км, Зүүнбаянгаас 2 орчим км зайтай байна. Төслийн талбайн байршилыг дараах зургаар харууллаа.



Зураг 1. Төслийн талбайн байршил

Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицлыг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд

№	Уртраг	Өргөрөг	X	Y
1	110° 3' 48.21"	44° 32' 11.13"	425573.31	4931884.39
2	110° 3' 40.82"	44° 31' 39.15"	425398.95	4930899.66
3	110° 3' 54.24"	44° 31' 37.59"	425694.59	4930847.85
4	110° 4' 01.62"	44° 32' 09.55"	425868.7	4931832.13

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.4. Төслийн хүчин чадал, техник технологи

1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга

Манай “Шижир Зүүнбаян Хөгжил” ХХК-ийн Зүүнбаян гаалийн хяналтын бүс нь 2022 оны 09 сарын 08-ний өдөр албан ёсоор гаалийн хяналтын бүсээр зарлагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн. Нүүрс ачиж буулгах талбайн нь төмөр зам болон автомашинаар ирсэн нүүрсийг хүлээн авч буулган, чингэлэгт ачиж төмөр замаар экспортод гаргах хүчин чадал бүхий 30 га гаалийн хяналтын бүс юм.

Ачилт. Ачилтыг 2 янзаар (хосолмол) хийж ажиллаж байна. Үүнд:


1. Машинаар задгай ирсэн нурмаг ачааг овоолго үүсгэн, ковшоор вагон болон автомашинд ачна.
2. Чингэлэгтэй нурмаг ачааг калимар ашиглан чингэлэг буулгах талбайд буулгаж ачна.



Зураг 2. Ачилт хийж буй байдал

Ачаа тээвэрлэлт:

- Нээлттэй чингэлэгээр тээвэрлэх
- Автомашинаар тээвэрлэх



Зураг 3. Ачаа тээвэрлэлт

Төмөр замаар тээвэрлэх маршрут


- Бүрэн ачаатай хөдлөх бүрэлдэхүүний хувьд: Ачилт буулгалтын талбай - Сайншанд
- Замын үүд - Эрээн;

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Ачаагүй хөдлөх бүрэлдэхүүний хувьд: Эрээн - Замын үүд - Сайншанд - Ачилт
буулгалтын талбай.


Автомашинаар тээвэрлэх маршрут. Нүүрсийг Таван толгой, “Айл баян” ХХК болон
“Сор говь” ХХК-ийн нүүрсний ордуудаас задгай машинаар тээвэрлэн авчирч нурмаг
бүтээгдэхүүний талбайд буулган овоолго үүсгэнэ.

Талбайн ерөнхий төлөвлөлтийн зохион байгуулалтыг дараах зургаар харуулав.



Зураг 4. Талбайн ерөнхий зохион байгуулалт

Талбайн бүтээн байгуулалт 2021 оны 11 сараас эхлэн 2022 оны 8 сар хүртэл хугацаанд хийгдсэн.



Зураг 5. Үйл ажиллагааны технологи дараалал

2022 онд төмөр замаар Цогтцэций-Зүүнбаян чиглэлд нийт 5 цуваа буюу 248 вагон 496 чингэлэг нүүрсийг талбайд хүлээн авч буулгалт хийсэн.


2022 онд төмөр замаар Зүүнбаян-Замын-Үүд Эрээн чиглэлд нийт 4 цуваа 198 вагон 396 чингэлэг нүүрсийг вагонд ачилт хийж экспортод гаргасан.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2022 онд “Өндөр жавхланта” уурхайгаас 48 удаа автомашинаар нүүрс тээвэрлэн ирж талбайд буулгалт хийсэн.


2023 онд төмөр замаар Цогтэций-Зүүнбаян чиглэлд нийт 17 цуваа буюу 798 вагон 1596 чингэлэг нүүрсийг талбайд хүлээн авч буулгалт хийсэн.

2023 онд төмөр замаар Зүүнбаян-Замын-Үүд Эрэн чиглэлд нийт 16 цуваа 798 вагон 1596 чингэлэг нүүрсийг вагонд ачилт хийж экспортод гаргасан.



Зураг 6. Төслийн ачилт буулгалтын талбай

Тээвэрлэж ирсэн нүүрсийг буулгахын өмнө, хилээр гаргах ачааг ачсаны дараа авто болон вагон пүүг ашиглан пүүлэгч жигнэн тооцоо хийнэ. Пүүний байранд Монгол улсын хэмжил зүйн стандартыг ханган ажиллаж байна.



Зураг 7. Авто пүү, пүүний байр

Төслийн талбайд нийт 7 техник ажиллаж байна. Үүнд: Калмар-1, Шанагат ачигч-1, Ачааны машин-3, Сэрээт ачигч-1, Бонго-1. Төслийн талбай дахь техник тоног төхөөрмжийг дараах байдлаар харууллаа.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 8. Төслийн техник, тоног төхөөрөмж

1.4.2. Төслийн дэд бүтцийн шийдлийн мэдээлэл

Төслийн талбайд чингэлэг сууцаар оффис байгуулсан, 2022-2023 онд нийт 4 хүний бүтэцтэй ажилласан. Ажилчдын амрах байрны хувьд төслийн талбайд ойр байрлах төмөр замын байранд байр түрээслэн ажиллаж байна.



Зураг 9. Төслийн талбайн оффис


Цахилгаан хангамж. Төслийн талбайн гэрэлтүүлэг болон дотоодын хэрэгцээг төвийн эрчим хүчний системээс хангадаг.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 10. Гэрэлтүүлэг

“Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг, Эрчим хүч ус хангамжийн II ангитай 3384 тоот гэрээний дагуу ханган ажиллаж байна.



Зураг 11. Цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг

Дулаан хангамж. Дулаан хангамжийн эх үүсвэрийг сонгохдоо Сайншанд сумын цаг уурын үзүүлэлт, оффисын барилгын овор хэмжээ, дулаан хэрэглэгчид болон тэдгээрийн үндсэн зориулалт тавигдах шаардлагын дагуу халаалтыг цахилгаан тень ашиглан хангаж байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 12. Дулаан хангамжийн эх үүсвэр цахилгаан халаагуур

Ус хэрэглээний эх үүсвэр. Төмөр зам болон авто тээврийн ачилт буулгалтын үйл ажиллагаа явуулахаа зөөврийн ус авч ашиглана. Төслийн талбайгаас 300-500 метрийн зайд байрлах худаас ахуйн хэрэглээний усаа зөөврөөр авч ашиглаж байна. Харин ундны усыг цэвэр усны савалгаатай усыг ашиглан хангаж байна.

Ариун цэврийн байгууламж. Төслийн талбайд ажиллаж буй ажилчдын ариун цэврийн байгууламжийг эколос бага оврын цэвэрлэх байгууламжаар шийдсэн. Цэвэршүүлсэн ахуйн бохир усаараа зам талбай, ногоон байгууламж услахаар төлөвлөсөн.



Зураг 13. Ариун цэврийн байгууламж байгуулж байгаа нь

Зам: Замын-Үүдийн төмөр замаас өөрийн талбай руу 2 салаа төмөр зам татсан.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 14. Шинээр байгуулсан төмөр зам, бүдүүвч зураг

Авто зам нь сайжруулсан шороон зам. Талбай доторх суудлын машин явах замууд болон хүнд даацын ачааны машин явах замууд нь сайжруулсан шороон зам байна.




Зураг 15. Зүүнбаян-төслийн талбай орчмын сайжруулсан шороон зам

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл

Цаг агаарын хувьд эх газрын уур амьсгалтай, хоногийн агаарын температур огцом өөрчлөлттэй. Жилийн дундаж температур $+4^{\circ}\text{C}$. Уур амьсгалын хувьд халуун хүйтний улирал болон өдөр шөнийн цагт хамгийн их зөрүүтэй ажиглагддаг. Зун нь дулаан урт үргэлжлэх ба өвлийн хүйтэн үе нь богино XII-I сар (-15°C - -21°C) хүртэл үргэлжилнэ. Харин халуун сар нь VII-VIII сар ($+20^{\circ}\text{C}$ - $+30^{\circ}\text{C}$) дээд температур $+39^{\circ}\text{C}$ хүйтэн нь -39°C хүрдэг байна. Агаарын улирлын дундаж даралтын өөрчлөлт бага боловч хоногийн хэлбэлзлийн хэмжээ их, заримдаа 30-40 мм м.у.б-д хүрнэ.




Зураг 16. Агаарын температурын жил, сарын явц

Жилд орох хур тунадасны хэмжээ 122.7-342.6 мм хооронд хэлбэлзэж өөрчлөгддөг ба дундаж утга нь 183-205 мм байна. Үүнээс хүйтний улиралд 7-12 мм, дулааны улиралд 117-332 мм байдаг. Хур тунадас гол төлөв зуны улиралд аадар бороо хэлбэрээр ордог ба энэ нь нийт хур тунадасны 85 %-ийг эзэлдэг юм. Цасан бүрхүүлийн зузаан 7-12 см-ээс хэтрэхгүй, харин гуу жалга, хотгор хэсгүүдэд 1 метр хүртэл нэмэгддэг. Хавар эхлэнгүүт цас хайлж газар доорхи усыг тэжээдэг онцлогтой. Хамгийн их хуурай, салхитай үед (IV ба V сард) заримдаа салхины хурд 20-25 м/с хүрч шороон шуурга үүсдэг. Улирлын хөлдөлтийн талбайн хэмжээнд 3.5 м. Улирлын хөлдөлт VI сард бүрэн гэнэ. Тус районд олон жилийн цэвдэг чулуулаг байхгүй. Жилийн салхины дундаж хурд 3.2 м/с, салхитай өдрийн тоо 59, хүчтэй салхитай өдрийн тоо 1.8 байна.

2.2. Газрын гадарга

Говийн гадарга нь сүүлийн үеийн уул үүсэх хөдөлгөөнөөр Монголын дорнод талынхтай нэгэн адил өндөрт өргөгдөөгүй, харьцангуй нам байдалтай үзэгджээ. Иймд ухаат, гүвээт тал, цав толгод, хотгор хонхор голлох суурийг эзэлдэг боловч энд тэнд нь, ялангуяа баруун хагаст нь уул нилээн тогтсон байна. Уулс нь төлөв Тэнгэр уулын тогтолцоонд хамаардаг тул тус орны үндсэн нуруудын суналаас өөр чиглэлтэй буюу өргөргийн дагуу сунаж тогтсон байна. Тэдгээрийн тоонд багтах Тахийн шар нуруу, Байтаг Богд, Атас Цагаан Богд зэрэг уулс 2400-2900 гаруй метр өндөр бөгөөд хотгор гүдгэрийн хувьд говь маягийн уулд хамаарна. Харин говийн зүүн хэсэгт байгаа уулс намхан, 1300-1800-аад метрээс үл хэтэрнэ. Эдгээр уулс ихэвчлэн баруун урдаас зүүн хойш чиглэсэн суналыг даган тогтжээ.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**




Зураг 17. Төслийн талбай орчмын геоморфологи

Төслийн талбай нь Дундговь-Өмнөговийн мужийн Галба-Өөшийн говийн (3) дэд мужид хамаарна. Тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь элэгдлийн гаралтай өргөгдмөл гадарга (Mz-Q)-ын Дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх элэгдлийн давхаргат талд байршина.

2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг

Районы геологийн тогтоцын хувьд Мезо-Кайнозойн настай тунамал ба хувирмал хурдас чулуулагаас бүрдэнэ. Мезо-Кайнозой нь цэрдийн үеийн тунамал баг бүрдүүлсэн байх бөгөөд энэ районд янз бүрийн ширхэглэлтэй элсэн чулуу, элс хайргархаг сланц, нягт шавар, конгломерат ба тэдгээрийн хувирмал хэсэг шавранцар ба шавар ихэвчлэн тархсан байна. Районы геологийн тогтоцод цэрдийн систем ба доод палеозойн бүлгийн тунамал чулуулгууд цаашилбал дээд палеозойн интрузив чулуулгууд оролцоно. Доод палеозойн /PZ1/ хурдас нь харьцангуй хязгаарлагдмал талбайгаар тархсан, үндсэндээ филиттэй төстэй сланец /занар/ кварцжсан элсэн чулуу, хаяа когломерат ба гранопилист голлосон сунамал нарийн шугаман байрлалтайгаар энэ районы зөвхөн доод хэсгээр тархсан байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 18. Төслийн талбай орчмын геологийн тогтоц

Дээд палеозойн системийн дунд-дээд карбоны интрузив /C2-3/ районы өмнөд хэсгээр харьцангуй ихээхэн талбайд тархсан байх ба тэрээр цагаан саарал ба бор өнгөтэй том ширхэгтэй грапитаас бүрдэнэ. Энэ нь ихэвчлэн толгодын орой, энгэрээр тархсан байна. Цэрдийн системийн Зүүнбаянгийн доод /K1dz/ хурдас нь уулын хөндий, уулын хажуу хормой, энгэрээр хамгийн их талбайг эзлэн тархжээ. Тэр нь маш ихээр нягтарсан аргиллиттай төстэй ногоовтор саарал, улаан бор, саарал-бор, боровтор-саарал, цайвар саарал өнгөтэй шавар зонхилсноор илэрч байна.

2.4. Гадаргын болон газрын доорх ус


Гадаргын ус. Говьд уур амьсгалаас шалтгаалж гадаргын ус тун ховор. Говийн гол мөрөн нийтдээ ганц Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарна. Говийн их муж нуур олонтой нутаг боловч говийн нуурын дийлэнх олонх нь гадагшаа урсгалгүй тогтуун учраас давсархаг буюу заримдаа бүр шорвог устай байна.

Төсөл хэрэгжих талбайн орчинд байнгын урсацтай гол горхи байхгүй.

Газрын доорх ус. Газрын доорх ус нь Монгол орны хамгийн чухал усны эх үүсвэр юм. Нийгэм эдийн засгийн бүхий л салбаруудын үйл ажиллагаа газрын доорх усны нөөц, түүний боломжоос шууд хамаардаг.

Говьд гадаргын ус нэгэнт ховор болохоор ус хангамжинд газар доорхи ус чухал ач холбогдолтой юм. Малчид, газар тариалан эрхлэгчид, уул уурхай болон үйлдвэрүүд нь үйл ажиллагаандаа газрын доорх усыг өргөнөөр ашиглаж байна. Чанарын хувьд ч ундны усны баталгаатай эх үүсвэр болдог.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 19. Төслийн талбай орчмын газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт

Говийн бүсийн газрын доорхи усны ерөнхий зүй тогтол нь цэрдийн шаврын зузаан үеийн доорхи ус нь усны эргэлтэнд удаан хугацаанд ордог, ус агуулагч чулуулгийн бүрэлдүүн зэргээс хамаарч усны эрдэсжилт нь их байдаг зэрэг онцлогтой. Газрын доорх усны горим жил бүр ихээхэн хэлбэлзэлтэй тогтворгүй, усархаг болон гантай жилүүдэд ээлжилж байдаг нь өмнөх жилийн түвшний нөлөөгөөр дараагийнханд нэмэлт нөлөөлөл үзүүлэх зүй тогтол илэрдэг. Газрын доорх усны түвшний уналт 5-6-р саруудад хамгийн доод цэгтэй хүрч, 7-8-р сард оргил үедээ хүрдэг ба түвшний хэлбэлзлийн утгууд нилээд тодорхой илэрсэн 2-3 оргил үүсгэх боловч заримдаа хугацааны ихээхэн хожимдолтойгоор 10-р сараас жилийн төгсгөл хүртэл түвшин жигд нэг байрлалд тогтсоор аажим буурах зүй тогтол ялангуяа нүх сүвт давхаргын ус тархсан сул шүүрэмхий бүсүүдэд түгээмэл байдаг. Судалгаа хийх нутаг дэвсгэрийн хэсэгт хуурай, сул элсэнцэр гадаргатай агааржилтын бүсийн зузаан найрлага харилцан адилгүй ба уул хоорондын хөндий тархалтын талбай харьцангуй ихтэй байна. Гол төлөв түрлэгтэйн уст үе давхрага зонхилж байдаг. Усжилтын хэмжээ бие даасан уст давхрагын тархалтын хэвтээ ба босоо чигт төрхдөсийн хувиралтай холбоотой түргэн өөрчлөгдөнө. Газрын доорх ус нь хур тунадасны усаар шууд тэжээгдэх боломж хомс бөгөөд толгод хоорондын хотгоруудыг тусгаарлаж байдаг өргөгдлийн талбайд унасан хур тунадасны усаар бүрдэх далд хэлбэрийн чөлөөт гадаргатай гүний усны тэжээгдэл урсацын бүрэлдэлтэнд голлох үүрэгтэй байдаг. Газрын доорх усны модулийн утга 0.01-0.3 л/см² байна.


2.5. Хөрсөн бүрхэвч

Сайншанд сумын нутаг дэвсгэр нь газрын гадаргын хувьд ерөнхийдөө уул нурууд байхгүй, ухаа гүвээт талын байрлалтай бөгөөд Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Говийн их мужийн Заримдаг цөлийн цайвар бор хөрсний дэд бүс нутгийн Алтан ширээн (10) тойрогт хамаарагдана (МУ-ын Үндэсний Атлас, 2009).

Ерөнхий хөрсөн бүрхэвчийн тархалт нь газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог тархалттай байна. Жишээ нь ухаа гүвээт талаар цөлөрхөг хээрийн бор мужийн хойт, зүүн, зүүн

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

өмнөт талын нутгаар цөлөрхөг хээрийн ердийн бор хөрс, бусад хэсэгт хээршсэн цөлийн цайвар бор хөрс голлох суурийг эзлэнэ. Хонхор хотгорын ёроол, хотос нам газраар хужир мараа, шал тойром, хужирлаг ба мараалаг хөрс элбэг тархсан. Уул толгодын энгэр хажуугаар сайр чулуурхаг бор, заримдаа цайвар хүрэн хөрс түгээмэл ажиглагдана.



Зураг 20. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч

Хөрсний улирлын хөлдөлтийн гүн өвөл 1,6-2,5 м хүрнэ. Өвөл -10°C-ийн температур хөрсөнд 40 см хүртэл гүн нэвтэрдэг. Зуны улиралд хөрс хүчтэй халж хөрсний гадарга дээрх температур +40-+60°C хүрэхийн хамт +15°C-ийн температур хөрсөнд 2-2,5 м гүн нэвчдэг. Хөрсний гадарга дээрх элс-сайр чулуун хучаас хэдий зузаан биш ч (0,5-2 см) хөрсний дулааны горимд тодорхой хэмжээгээр нөлөөлж хөрсний өнгөн хэсгийг хэт халалтаас хамгаалдаг онцлогтой.

Талбайн хэмжээнд заримдаг цөлийн цайвар бор хөрс тархана. 1 хэв шинж, 2 дэд хэв шинжийн хөрс (заримдаг цөлийн элсэнцэр цайвар бор хөрс, заримдаг цөлийн хөнгөн шавранцар бор хөрс) тархсаны төсөл хэрэгжих талбайн ихэнхи хэсэгт заримдаг цөлийн элсэнцэр цайвар бор хөрс тархсан байна. Хөрсний өнгөн гадарга голдуу элсэн-элсэнцэр сайр чулуу багатай 40% хүрнэ. Үлдсэн талбайд тархсан заримдаг цөлийн хөнгөн шавранцар бор хөрсний өнгөн гадарга жижиг сайр чулуурхаг-50%, бутлаг бударганы төрлийн ургамлын бүрхэц 10%. Судалгааны талбайн хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, өнгөн үед бага, гүнрүүгээ дунд зэрэг карбонаттай, ялмагийн агууламжаар маш бага, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар маш бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр, хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

Хөрсний элэгдэл, эвдрэл. 30 га газрыг хамрах төслийн талбайн хувьд салхины жилийн дундаж хурд 3.2 м/с, жилийн дулааны улиралд дундаж харьцангуй чийгшил 58 хувь, 0-4 градусын налуу бүхий газар байршдаг, хөрсний 0-15 см-ын үе давхаргадаа ялмагийн агууламж нь маш бага (0.197-0.301), 0-15 см-ын үе давхаргад элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй буюу шаврын (<0.002 мм) эзлэх хэмжээ нь 0.09-0.2 хувь байна, ургамлын бүрхэц талбайн хэмжээнд


**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

дунджаар 33 хувьтай байгаа нь талбайн хэмжээнд тархсан хөрс нийтдээ эмзэг төрлийн хөрстэй, өнгөн сайр чулуун хучаас сөхөгдөж, хөрс ухагдаж эвдрэлд орсон тохиолдолд салхи, усны нөлөөгөөр амархан элэгдэж, эвдрэлд орох шинжтэйг харуулж байна.

Хөрсөн дэх хүнд металлын агууламж, бохирдол. Талбайгаас дээж авч хүнд металлын агууламжийг үндсэн 6 элементээр тодорхойлоход хөрсөн дэх кадми /Cd/, никель /Ni/, цайр /Zn/, зэс /Cu/-ийн агууламж стандарт хэмжээнд, харин хар тугалга /Pb/, хром /Cr/ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс бага зэрэг их агууламжтай байна.

2.6. Ургамлан нөмрөг

Дорноговь аймгийн Сайншанд суманд байрлах талбайн хэсэг нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагддаг. Төслийн талбай нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө цөлийн хээрийн ургамалжилтай.



Зураг 21. Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг

Хазаар өвс –орог тэсэгт бүлгэмдэл. Тусгагийн бүрхэц 33%, нийт 18 зүйлийн ургамал ургана. Зонхилогч ургамлын хувьд үетнээс өдлөг хялгана, зүүнгарын хазаар өвс, дэрс, монгол ерхөг алаг өвснөөс таана, хөмүүл, нарийн улалж, аммоний сэдэргэнэ, янгиц, цөөн наст ургамлаас булган сүүл, бага хургалж, толгодын будраа, шүлхий шарилж, сөөглөг ургамлаас бор бударгана, орог тэсэг, ахар навчит баглуур, хармаг, улаан бударгана, алтлаг харгана ургах бөгөөд 100м² талбайд 52 ш 5-40 см диаметртэй ургана. Бүлгэмдэлд 20-40 см өндөр сөөг дээд ташинга, 5-25см өвслөг ургамал доод ташинга үүссэн. Ашигт ургамлын жагсаалтанд элбэг тархалттай 4 зүйл (*Convolvulus ammonii* –аммоний сэдэргэнэ, *Allium mongolicum*- хөмүүл, *Allium polyrrhizum*-таана, *Allium anisopodium*- шувуун хөл сонгино) ургана. Бэлчээрийн талхлагдал дунд.

Ахар навчит баглуур - Улаанбударганат бүлгэмдэл. Зүйлийн бүрэлдэхүүн 19, ургамлын бүрхэц 27%, үүнээс сөөгний бүрхэц 15 %. Ургамлан нөмрөгийн өндөр 5-10 см, улаан бударгана, шар бударганы буттай. Ургац 1 м² талбайд 3.2 ц/га. Зонхилогч ургамлын хувьд үетнээс дэрвээн хазаар өвс, говийн хялгана, алаг өвснөөс толгодын бударгана, таана хөмүүл ургана. Талхлагдал

бага. Энд ургамлын нөөцийн төрөл зүйлийн ЭЭЗҮ-ний нэн ховор тархалттай ургамлын жагсаалтанд орсон хулангийн ундаа 1-ээс бага арвитай ургасан.

Баглуурт, хармаг - Шар бударгана, хармагт бүлгэмдэл. Тусгагийн бүрхэц 35- 45%, 17 зүйлийн ургамал бүртгэгдсэн, ургац 4,8 ц/га. Зонхилогч ургамлын хувьд үетнээс дэрс, алаг өвснөөс сибирь агь, хависгана заримдаг сөөгөнцөрөөс баглуур, хармаг, шар бударгана, улаан бударгана ургана. Ашигт ургамлын жагсаалтанд элбэг тархалттай 3 зүйл (*Allium polyrrhizum*– таана, *Convolvulus ammonii*-Аммоний сэдэргэнэ, *Peganum nigellastrum*- өмхий өвс) ургамал ургана. Бэлчээрийн талхагдал дунд зэрэг. Ургамлын NDVI-ыг тооцоолсон зургаас ургамалжлын нормчилсон утга нь 0.1-0.45 хооронд байсан бөгөөд цөлөрхөг хээрийг илтгэж байна.

2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил

Сайншанд сум нь Улаанбаатар – Замын Үүд босоо тэнхлэгийн засмал зам болон Олон улсын төмөр замын зангилаан дээр байрладаг, төвийн эрчим хүчний системд холбогдсон, дэд бүтэц хөгжсөн хот юм.

Төсвийн орлого, зарлага: Төмөр замын томоохон боомт хотуудын нэг. Аж үйлдвэрийн салбар өнгөрсөн онд 5.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 4.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулсан байна.


5-р баг (Зүүнбаян). Зүүнбаян нь Сайншанд сумаас урагш 50 км-т оршдог. 2020 оны жилийн эцсийн байдлаар 5-р баг (Зүүнбаян)-т 558 өрхийн нийт 2006 хүн оршин сууж байна. Сумын нийт хүн амын 53% нь эмэгтэй, 47% эрэгтэй байна. Малын 2020 оны тооллогоор нийт 33760 толгой мал тоологдсон нь 2019 оноос 3140 толгой малаар өссөн. Багийн малтай өрхийн тоо 2020 оны байдлаар 96 болж өмнөх оноос 5 өрхөөр өссөн гарчээ. Нийт тэмээ 1790, адуу 2000, үхэр 1150, хонь 16890, ямаа 11930 тоо толгой байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд


3.1.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт нөлөөлөх нь:

Нүүрс ачиж буулгах талбайн тоосжилт. Нүүрс ачиж, буулгах үед нүүрснээс орчны агаарт тоос дэгддэг. Нүүрс ачиж буулгах талбайгаас үүсэх TSP болон PM10, PM2.5 тоосонцрын ялгарлын хэмжээг жилийн дундажаар тархалтын загвараар тооцов. TSP буюу нийт тоосонцор нүүрс ачиж, буулгах талбайд жилийн дундаж агууламжийг хамгийн ихдээ 100-450 мкг/м³-иар орчны агууламжийг нэмэгдүүлэхээр байна.



Зураг 22. Ачилт, буулгалтын талбайгаас ялгарах TSP тоосны жилийн дундаж агууламж, мкг/м³

Энэ нь нийт тоосны хувьд MNS 4585:2016 агаарын чанарын стандартын жилийн дундаж ЗДХ болох 100 мкг/м³ агууламжийн хэмжээнээс 1-4 дахин давах үзүүлэлттэй байна. Харин төслийн нийт талбайгаар дунджилсан агууламж 59.7 мкг/м³ байна.



Зураг 23. Ачилт, буулгалтын талбайгаас ялгарах PM10 тоосны жилийн дундаж агууламж, мкг/м³

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

PM10 тоосонцор нүүрс ачиж, буулгах талбай орчим 50-74 мкг/м³, төслийн нийт талбайн жилийн дундаж агууламж 21 мкг/м³ байхаар байна.

Харин төслийн талбайгаас 800 м орчим зайд байрших суурьшилын бүсэд нүүрс ачиж буулгах талбайгаас ялгарах нийт тоосонцрын агууламж 6 мкг/м³, PM10 тоосонцор 1 мкг/м³-аар орчны агууламжийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт 2. Агаарт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин

№	Нөлөөлөл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Ачааг машинаар тээвэрлэх болон ачиж буулгах үед тоосжилт үүсэх	-1	2	3	3	1	2	1	-12	Их сөрөг нөлөөтэй	Төслийн үйл ажиллагааны үед төслийн талбайд хийгдэх механик ажлын нөлөөллөөр орчинд тоосжилт үүсгэнэ.
2	Ачаа тээвэрлэлтийн үед хүнд даацын тээврийн хэрэгслийн Хөдөлгүүрээс хорт хий ялгарах	-1	2	2	2	1	2	1	-10	“Дунд зэрэг” сөрөг нөлөөтэй	Тээврийн хэрэгслүүдийн дутуу шаталгат хөдөлгүүрээс хорт хий ялгарах боломжтой.
3	Нүүрсний овоолгоос тоосжилт үүсэх	-1	2	2	3	1	2	1	-11	“Дунд зэрэг” сөрөг нөлөөтэй	Агаар мандалд үүсэх тоосны нийт хэмжээ салхины хурд ихтэй үед ихсэнэ.
4	Төслийн талбай орчмын элэгдэл эвдрэлд өртсөн талбайгаас салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх	1	2	2	3	1	2	1	-11		
5	Төслийн талбай дахь ахуйн хатуу болон шингэн хаягдлын цэгээс дулааны улиралд эвгүй үнэр гарах, агаар бохирдуулах	-1	2	2	2	1	2	1	-10	“Бага” сөрөг нөлөөтэй	Боловсон бие засах газар байгуулаагүй болон хаягдлын цэгийн битүүмжлэл муугаас орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.
6	Агаарын физик бохирдол үүсэх	1	2	2	2	1	2	1	-10	“Дунд зэрэг” сөрөг нөлөөтэй	Бүтээн байгуулалтын үед болон үндсэн үйл ажиллагааны үед вагон болон автомашины ашиглалтаар дуу чимээ үүснэ.

Дүгнэлт: Ихэнх нөлөөлөл “Дунд зэрэг” сөрөг нөлөөтэй байна.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

3.1.2. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлөх нь:

30 га газрыг хамрах төслийн талбайн хувьд салхины жилийн дундаж хурд 3.2 м/с, жилийн дулааны улиралд дундаж харьцангуй чийгшил 58 хувь, 0-4 градусын налуу бүхий газар байршдаг, хөрсний 0-15 см-ын үе давхаргадаа ялзмагийн агууламж нь маш бага (0.197-0.301), 0-15 см-ын үе давхаргад элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй буюу шаврын (<0.002 мм) эзлэх хэмжээ нь 0.09-0.2 хувь байна, ургамлын бүрхэц талбайн хэмжээнд дунджаар 33 хувьтай байна. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшинг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 3. Хөрсөнд үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин

№	Нөлөөлөл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Бүтээн байгуулалтын үед газрын хөрс элэгдэж, эвдрэх	-1	3	3	2	1	2	1	-12	“Дунд зэрэг”сөрөг нөлөөтэй	30.0 га талбайн хөрс нөлөөлөлд өртөж элэгдэл, эвдрэлд орно.
2	Ачааг хүнд даацын машин механизм ашиглан тээвэрлэх үед төслийн талбайн орчны газрын гадарга, хөрс элэгдэж эвдрэх	-1	2	2	2	2	2	1	-11	“Дунд зэрэг”сөрөг нөлөөтэй	Тээвэрлэлтийн үед элэгдэж эвдэрсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
3	Ахуйн хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох хөрсний биологийн бүтэц ба физик химийн шинж чанар өөрчлөгдөх	1	3	3	3	1	3	1	-14	“Дунд зэрэг”сөрөг нөлөөтэй	Стандартын шаардлага хангасан бохирын цооног, хог хаягдлын цэг байгуулаагүйгээс хөрсний бохирдол үүсгэнэ
4	Машин механизмын тос тосолгооны материалаар хөрсний бохирдол үүсэх	-1	3	3	3	1	3	1	-14	“Дунд зэрэг”сөрөг нөлөөтэй	Тээврийн машин механизмаас тос тосолгооны материал гоожиж хөрс бохирдуулж болзошгүй
Бүх нөлөөлөл сөрөг нөлөөтэй байна. Нийт нөлөөллүүд нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.											

3.1.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд нөлөөлөх нь:

Газрын гадаргын хувьд ерөнхийдөө уул нурууд байхгүй, ухаа гүвээт талын байрлалтай. Талбай орчмын гадаргуугийн өндөр нь 682-805 м өндрийн түвшинд хэлбэлзэнэ. Төмөр зам болон авто тээврийн ачилт буулгалтын талбайн нэгж талбар нь нийт 300000 м² талбай байгаагаас, 96000 м² талбайд контейнер байрлах талбай, 60000 м² талбайд нурмаг бүтээгдэхүүн хадгалах талбай, 2.128 км урт 2 салаа төмөр зам, 150 м² талбайд барилга байгууламжууд баригдана. Салхины хаалт бүхий 6-8 м өндөртэй хашааг талбайн салхин талд байрлуулахаар төслийн төлөвлөлтөд тусгасан.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 4. Газрын гадаргад үзүүлэх болдошгүй нөлөөллийн түвшин

№	Нөлөөлөл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Нийт талбайн газрын гадаргын байгалийн унаган төрх өөрчлөгдөх, эвдрэх	-1	3	3	2	1	2	1	-12	“Дунд зэрэг” сөрөг нөлөөтэй	Нөлөөлөлд өртөөгүй унаган байгаль эвдэгдэнэ
2	Ашиглах талбайн хэмжээгээр антропоген болон техноген нөлөөлөлд өртөх	-1	2	2	2	1	2	1	-10	“Дунд зэрэг” сөрөг нөлөөтэй	Бүтээн байгуулалтын үед талбай бүхэлдээ өөрчлөлтөнд орно
Дүгнэлт: Бүх нөлөөлөл дунд зэрэг сөрөг байна.											

3.1.4. Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх нь:

Төслийн талбайгаас 10 орчим км зайд Зээгийн хөтөлийн хэсэг дэх Сайншанд хотын төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорхи усны орд оршдог. Дээрхи талбайн хэмжээнд дээд цэрдийн Сайншандын давхаргадасын янз бүрийн ширхэгтэй сул барьцалдсан элс, хайргажингийн зузаалагт зонхилон тархсан 2.5-5.4 мг-экв/л ерөнхий хатуулаг, 0.3-1.0 г/л эрдэсжилт бүхий газрын доорхи ус нь тухайн орчны газрын гадаргуугийн хотгор гүдгэрийн хэв шинжийн дүрс зүйн онцлогоос шууд хамаарч (усны тогтонги түвшиний гүний байршил) 3.2-42.2 м гүнд илэрдэг ба гидрогеологийн цооногийн ундарга 2.0-27.0 л/с, усны түвшиний бууралт 2.5-14.2 м байна. Уг тунамал хурдасны доторхи дунджаар 30.0-48.0 м зузаантай уст үе давхаргын шүүрлийн итгэлцүүр 8.5-10.6 м/хоног, усны түвшиний өөрчлөлтийг дамжуулах чадвар $0.84 \times 10^4 - 3.73 \times 10^4$ м²/хоног болно. Төслийн үйл ажиллагааны улмаас усны нөөц, чанарт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшинг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 5. Усны нөөц, чанарт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин

№	Нөлөөлөл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Газрын доорхи усны нөөцөд нөлөөлөх	-1	2	3	2	2	2	2	-13	“Бага зэрэг” сөрөг нөлөөтэй	Ажилчдын ахуйн хэрэглээ болон зам талбайн усалгаанд газрын гүнийцэвэр ус (жилд 27220 м3) ашиглах тул энэ нь цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлнө
Дүгнэлт: Дунд зэргийн сөрөг нөлөөтэй байна.											

3.1.5. Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт нөлөөлөх нь:

Тус талбай нь тэгш талд байрлах бөгөөд гуу жалга, ус урсах хэсгээг хамрах бөгөөд баглуурт, хармаг-шар бударгана, хармагт бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 35-45%, 17 зүйлийн ургамал (бичиглэл-3) бүртгэгдсэн, ургац 4,8 ц/га байсан. Энэ бүлгэмдэл нь талбайд зонхилогч ургамлын хувьд үетнээс дэрс, алаг өвснөөс сибирь агь, хависгана заримдаг сөөгөнцөрөөс баглуур (1м*1м талбайд 5см*8см диаметртэй 2 ш), хармаг (10м*10м талбайд 30см x10см диаметртэй 1 ш, 50см*80см диаметртэй 1ш, шар бударгана (10м*10м талбайд 3 ш), улаан бударгана (10м*10м талбайд 15см*10см диаметртэй 2 ш) ургана. Ашигт ургамлын жагсаалтанд элбэг тархалттай 3 зүйл (*Allium polyrrhizum* –таана, *Convolvulus ammonii*-Аммоний сэдэргэнэ, *Peganum nigellastrum*-

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

өмхий өвс) ургамал ургана. Бэлчээрийн талхагдал дунд зэрэг. Тус ачилт буулгалтын талбайн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшинг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6. Ургамлан нөмрөгт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин

№	Нөлөөлөл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Бүтээн байгуулалтын үед ургамлан нөмрөг талхлагдах, зулгарах, устах	-1	3	3	2	1	2	1	-12	“Дунд зэрэг”сөрөг нөлөөтэй	30.0 га талбайн ургамлан нөмрөг сөрөг нөлөөлөлд өртөж зулгарч устана.
2	Тээвэрлэлтийн үед автомашины хөдөлгөөнөөр ургамал талхлагдах, зулгарах, устах	-1	2	2	2	2	2	1	-11	“Дунд зэрэг”сөрөг нөлөөтэй	Тээвэрлэлтийн үед элэгдэж эвдэрсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
3	Машин механизмын тос тосолгооны материалаар хөрс бохирдсоноор ургамал ургах орчин үгүй болох	-1	3	3	3	1	3	1	-14	“Дунд зэрэг”сөрөг нөлөөтэй	Тээврийн машин механизмаас тос тосолгооны материал гоожиж болзошгүй
Дүгнэлт: Бүх нөлөөлөл сөрөг нөлөөтэй байна. Нийт нөлөөллүүд нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.											

3.1.6. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлөх нь:

Судалгааны талбай нь Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн мужлалаар цөлөрхөг хээрийн экосистемийн төлөөлөл болсон өвөрмөц бүс нутаг юм. Энэ тойргийн хөхтөн амьтны гол төлөөлөл нь Төв азийн уугуул зүйл болох Цагаан зээр (*Procapra gutturosa*), зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) II-р хавсралтанд орсон, Монгол улсын хуулиар агнахыг тусгаалан хориглосон Саарал чоно (*Canis lupus*), мөн түүнчлэн Монгол оронд төдийгүй дэлхийд ховордож буй Монгол хулан (*Equus hemionus*), хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) гэх мэт хөхтөн амьтан; CITES-ийн II-р хавсралтанд орсон Идлэг шонхор, шууман шонхор, шар шувуу, хотны бүгээхэй зэрэг шувуудаар баялаг юм. БОННУ-ний хээрийн судалгаагаар гар далавчтан, зараатан, махчтан, мэрэгчтэн, шавьж идэштэн, туруутан, туурайтан, туулайтан зэрэг 8 багт хамаарах 15 овгийн 49 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгдсэн.

Хүснэгт 7. Амьтны аймагт үзүүлэх болзошгүй нөлөөллийн түвшин

№	Нөлөөлөл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Бүтээн байгуулалтын үед мөлхөгч амьтад үрэгдэх	-1	3	3	2	1	2	1	-12	“Бага зэрэг”сөрөг нөлөөтэй	Барилгын ажлын үед мөлхөгч жижиг

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

											амьтад өртөж болзошгүй.
2	Ан амьтад үргэж дайжих	-1	2	2	2	2	2	1	-11	“Бага зэрэг”сөрөг нөлөөтэй	Машин техникийн хөдөлгөөн, чимээ шуугиан тасралтгүй үргэлжилснээс ойр орчны ан амьтад үргэж дайжина.

Дүгнэлт: Бүх нөлөөлөл сөрөг нөлөөтэй байна. Нийт нөлөөллүүд нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.

3.1.7. Төслийн үйл ажиллагааны нийгэм, эдийн засагт нөлөөлөл нь:

Сайншанд сум нь Улаанбаатар – Замын Үүд босоо тэнхлэгийн засмал зам болон Олон улсын төмөр замын зангилаан дээр байрладаг, төвийн эрчим хүчний системд холбогдсон, дэд бүтэц хөгжсөн хот юм.

Нутаг дэвсгэр: Улаанбаатараас 463 км зайтай газарт, далайн түвшнээс дээш 938 м өндөрт оршино. 234.6 га газар нутагтай.

Хүн ам: 2022 оны жилийн эцсийн байдлаар 7839 өрхийн нийт 27405 хүн оршин сууж байна. Нийт хүн амын 51.7% нь эмэгтэй, 48.3% эрэгтэй байна. Өмнөх жилтэй харьцуулахад 1415 хүнээр өссөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Сайншанд сумын хэмжүүнд нь хөдөлмөрийн насны иргэн 12,3 мянган ажиллагсад байна. Төрийн байгууллагад 15.7 хувь, үйлчилгээний салбарт 25 хувь, ХАА болон бусад салбарт үлдсэн хувь нь ажиллаж байна.

Боловсрол: Ерөнхий боловсролын таван сургуулийн 152 бүлэгт 4804 хүүхэд сурч, 231 багш ажиллаж, багшлах боловсон хүчин 100 хувь хангагдсан. Сайншанд сумын харьяаны 9 цэцэрлэгийн нийт 50 бүлэгт 1534 хүүхэд сурч хүмүүжиж байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 856, Төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 168, ЭМШУИС-ийн Дорноговь салбар сургуульд 1035 оюутан, сурагч суралцаж байна.

Эрүүл мэнд: Сайншанд сумын нэгдсэн эмнэлэг нь их эмч, 5 сувилагч, 2 асрагч, 3 туслах ажилтан, 8 ортой. Тус эмнэлгээр жилдээ 295-300 орчим иргэд хэвтэн эмчлүүлдэг. Өдөрт амбулаторид 20-30 гаруй иргэн үзлэгт хамрагддаг байна.

Мал аж ахуй: 2022 оны малын тооллогоор нийт 139830 толгой мал тоологдсон нь 2019 оноос 147300 толгой малаар өссөн. Сумын малтай өрхийн тоо 2020 оны байдлаар 484 болж өмнөх оноос 39 өрхөөр өссөн үзүүлэлт гарчээ. Нийт тэмээ 45.38, адуу 165.03, үхэр 103.75, хонь 1069.69, ямаа 1167.7 мянган тоо толгой байна.

Газар тариалан: Сайншанд сумын хэмжээнд 32 иргэн, 1 аж ахуйн нэгж газар тариалан эрхэлдэг. 25.1 га-д тариалалт хийснээс 11.6 га-гаас 58,6 тн төмс, 9,8 га-гаас 63.2 тн хүнсний ногоо, 3.69 га-гаас 9,1 тн тэжээлийн ургамал, нийт 130.9 тн ургац хураан авсан.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсвийн орлого, зарлага: Төмөр замын томоохон боомт хотуудын нэг. Аж үйлдвэрийн салбар өнгөрсөн онд 5.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 4.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулсан байна.


Хүснэгт 8. Нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн түвшин

№	Нөлөөлөл	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	D u	R	Σ		
1	Ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэх	+1	1	3	2	3	2	2	+13	“Эерэг” нөлөөлөл дунд зэрэг	Төсөл хэрэгжих хугацаанд тодорхой тооны иргэд тогтмол ажлын байраар хангагдана.
2	Эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулах	+1	1	3	2	3	2	2	+13	“Эерэг” нөлөөлөл дунд зэрэг	Улсын төсөвт татвар хураамж төвлөрүүлэх замаар эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлнө.
3	Монгол улсын экспортын бараа бүтээгдэхүүний хэмжээ өсөх	+1	1	2	2	2	2	2	+11	“Эерэг” нөлөөлөл дунд зэрэг	Замын-Үүдийн боомтоор нэвтрүүлэх зөвшөөрлийн дагуу
4	Агаарын бохирдлын улмаас ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	-1	2	3	3	1	2	1	-12	Их сөрөг нөлөөтэй	Орчинд тоосжилт ихээр үүсэх, мөн хүнд даацын машин механизмын хөдөлгүүрээс гарах агаар бохирдуулагч хорт бодисын нөлөөгөөр мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөж болзошгүй.
Дүгнэлт: Бүх нөлөөлөл сөрөг нөлөөтэй байна. Нийт нөлөөллүүд нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.											

3.2. Төслийн гол сөрөг нөлөөлөл

Төмөр зам болон авто тээврийн ачилт буулгалтын талбай байгуулах төслийн барилга, газар шорооны ажил болон төслийн үйл ажиллагааны үед хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн түвшинг тогтоох зорилгоор эерэг болон сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллүүдийн эрчмийг нь тодорхойлбол нийт нөлөөллийн 13.6% нь эерэг нөлөөлөл, 21.1% нь бага хүчтэй сөрөг нөлөөлөл, 68.4% нь дунд зэргийн хүчтэй сөрөг нөлөөлөл, 10.5% нь их эрчимтэй сөрөг нөлөөлөл байна.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 24. Төслийн үйл ажиллагааны явцад илрэх эерэг ба сөрөг нөлөөллийн эзлэх хувь

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тодорхойлсон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн эрчмийг доорх зургаар үзүүллээ.



Зураг 25. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн эрчим

Үйл ажиллагааны явцад аюултай сөрөг нөлөөлөл ажиглагдахгүй бөгөөд орчны бүрэлдэхүүн хэсгүүдээс агаар мандал, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт хамгийн их сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Их эрчимтэй нөлөөлөл нь агаар орчинд үзүүлэх тоосжилтын нөлөө байхаар байна.

Агаар мандал: Төслийн барилга бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явагдаж эхлэх үед тухайн орчны элэгдэж эвдэрсэн зам талбайгаас тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон салхины үйлчиллээр тоосжилт үүсэх, хүнд даацын автомашины хөдөлгүүрээс үүсэх хорт хий зэрэг нь орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө. Үндсэн үйл ажиллагааны үед нүүрс ачих, буулгах үед болон нүүрсний овоолгоос салхины үйлчлэлээр, ачаа тээврийн автомашины хөдөлгөөнөөр үүсэх

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН
АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

тоосжилт болон тэдгээрийн хөдөлгүүрээс үүсэх хорт хий зэрэг нь орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.

Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг: Талбайн хэмжээнд тархсан хөрс нийтдээ эмзэг төрлийн хөрстэй, өнгөн сайр чулуун хучаас сөхөгдөж, хөрс ухагдаж эвдрэлд орсон тохиолдолд салхи, усны нөлөөгөөр амархан элэгдэж, эвдрэлд орох шинжтэй байна. Иймд барилга, бүтээн байгуулалтын үед нутаг дэвсгэрийн өнгөн хөрс элэгдэл эвдрэлд өртөж, ургамал талхлагдаж, зулгарч, устаж үгүй болно. Мөн талбайд байгуулагдах авто зам, бусад нүүрс хадгалах, ачих буулгах талбайнуудын хөрсийг хайргаар болон байгалийн хөрсийг нягтаршуулж ашиглахаар төлөвлөж байгаа зэргээс хөрс элэгдэх нөхцөл ихтэйг харуулж байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт байрлах “Төмөр зам болон авто тээврийн ачилт, буулгалтын талбай” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн технологи ажиллагааны онцлогтой нь уялдуулан ОУ-ын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох арга, аргачлалын дагуу байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тус бүрд нь авч үзсэний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах бусад багц хууль, холбогдох журам, зааврын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй төслийн хэрэгжилтийн үе шатанд байгаль хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр нь бууруулж нөхөн сэргээх зорилтыг хангах үүрэгтэй юм.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тусгасан байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлж, тухайн жил бүр мөрдөн ажилладаг байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оршино.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь төслийн төгсгөлийн ажлын үе шатанд байгаль орчинд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, зардал, хариуцах эзний хамтаар төлөвлөн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахад чиглэнэ.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТӨМӨР ЗАМ БОЛОН АВТО ТЭЭВРИЙН АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ”
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган 2024 онд хэрэгжүүлэх байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /төг/	Тоо, хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<i>Агаар орчин</i>								
